



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/696

Мөрөн сум

Гадаад албан томилолтоор
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академи, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Боловсролын гадаад оюутны төвтэй хамтран зохион байгуулах тус орны орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн туршлагатай танилцах арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Г.Гандэлгэрийг оролцуулж, 2025 оны 01 дүгээр сарын 05-10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад гадаад албан томилолтоор ажиллуулсугай.

2. Г.Гандэлгэрийн тус орны орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн туршлагатай танилцах арга хэмжээнд оролцоход шаардагдах зардлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д даалгасугай.

3. Гадаад албан томилолтоор ажиллаж, туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан тухай илтгэх хуудсыг ажлын 5 хоногийн дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Гандэлгэр)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Энхзаяа)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Ц.ГАНСҮХ

